

МОНГОЛ – ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ IV (МГТИС) ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ТУХАЙ

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байх хэмээн 2016 онд баталсан. 2012 оноос, Монгол Улсын засгийн газар нь аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-ын хэрэгцээ, шаардлагад нийцсэн ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалт, судалгаанд тулгуурласан дээд боловсролын салбар дахь шинэчлэлийг эхлүүлсэн.

МГТИС нь боловсролын салбарын шинэчлэлтэй хөл нийлүүлж, Монгол улсын ашигт малтмал болон үйлдвэрлэлийн салбаруудад эрэлттэй өндөр мэргэшсэн инженерүүдийг бэлтгэдэг. Түүнчлэн, олон улсын шинжлэх ухааны салбар дахь туршлага, орчин үеийн эрдэм шинжилгээний стандартыг Монгол улсад нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Төсөл нь МГТИС-ийн институтийн болон санхүүгийн чадавхыг сайжруулахад дараах байдлаар дэмжин ажиллана:

- МГТИС-ийг зорин суралцах залуусын сонирхлыг нэмэгдүүлэх
- МГТИС ба ААНБ-уудын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Чанарт суурилсан, үр ашигтай сургууль болоход дэмжих
- Сургуулийн хотхоныг өргөтгөх

Төсөл нь МГТИС-ийг салбартаа тэргүүлэгч болох, сургалт, судалгааны үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэхэд дэмжин ажиллаж байна.

ЗОРИЛГО

Монголын эдийн засагт шинжлэх ухаанч ноу-хау-ыг бий болгох, мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх МГТИС-ийн чадавхыг бэхжүүлэх

| | |
|-----------------------------|--|
| Захиалагч | ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ) |
| Төслийн хэрэгжих бүс, нутаг | Налайх / Улаанбаатар |
| Хэрэгжүүлэгч байгууллага | Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) |
| Хугацаа | 01/2024 - 12/2026 |



Туршилт хийж буй оюутнууд



ЗАЛУУСЫН СОНИРХЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Төсөл нь МГТИС-ыг сонирхож, зорин ирэх залуусын сонирхлыг нэмэгдүүлэхэд дэмжин ажиллана.

Академик хөтөлбөрүүдийг үнэлж дүгнэх, ХБНГУ болон бусад олон улсын их дээд сургуулиудын хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэхэд тогтмол дэмжлэг үзүүлнэ.

Оюутны элсэлт, сургалт, дадлагын орчныг сайжруулах арга хэмжээнүүдэд зөвлөн, дэмжихээс гадна сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэхэд хамтран ажиллана.



ААНБ-УУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

Хэрэглээний судалгаа хийх, давтан, мэргэшүүлэх сургалтыг хөгжүүлэх хүрээнд ААНБ-уудтай хамтран ажиллах, харилцаагаа бэхжүүлэхэд төсөл дэмжин ажиллана.

МГТИС-ийн стратегийн судалгаа хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг үнэлж, шинэчлэн хэрэгжүүлнэ.

ААНБ-уудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн инженер техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтуудыг санал болгодог, ААНБ-уудын түншлэгч сургалтын байгууллага болон хөгжихөд дэмжин ажиллана.



МГТИС-ийн төгсөлтийн баяр



ЧАНАРТАЙ, ҮР АШИГТАЙ ИХ СУРГУУЛЬ

Заах аргазүй болон мэдээллийн технологийн дэд бүтэцтэй холбоотой цахим болон танхим хосолсон сургалтын загварыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Хүний нөөц, хамтын ажиллагаа, хөрөнгө босгох, харилцаа холбоог сайжруулах зэрэг сургуулийг чанаржуулах, үйл ажиллагааг үр ашигтай байлгах талаар зөвлөн дэмжинэ.

МГТИС нь Монголын дээд боловсролын тогтолцоонд үлгэр жишээ болохуйц байж, удирдлагын бүтцээ орчин үеийн зарчимд нийцүүлэн, байгууллагын бие даасан байдлыг ханган ажилладаг. МГТИС-ийг мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхэд төсөл дэмжин ажиллана.



СУРГУУЛИЙН ХОТХОНЫ ӨРГӨТГӨЛ

Санхүүгийн болон техникийн хамтын ажиллагааны хүрээнд, МГТИС-ийн хотхоныг өргөтгөж байна. Олон талт үйл ажиллагаа бүхий барилгыг 2025 оны намар ашиглалтад оруулна. Барилгын ажлыг санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд санхүүжүүлж байгаа бол лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг төсөл хамтран хариуцаж байна. Шинэ лабораториуд нь МГТИС-ийн судалгаа хийх боломж, чадавхыг дээшлүүлэх гол бааз болох юм.



Оюутны талархал

Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)

Холбоо барих: Себастиан Бургхоф
"Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль – IV" (МГТИС) төсөл
Найман зовхис барилгын V давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251, Монгол улс

Утас: +976 11 31 3030
И-мэйл: sebastian.burghof@giz.de
Веб: www.giz.de/mongolia

Огноо: 2024 оны 1-р сар

Зураг: Энхбаяр Пүрэвдорж

Дизайн: Монгол дахь GIZ

Хамтран хэрэгжүүлэгч: Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)

Захиалагч: ХБНГУ-ын Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)

Хэвлэлийн агуулгыг Монгол дахь GIZ хариуцна.

GERMAN-MONGOLIAN INSTITUTE FOR RESOURCES AND TECHNOLOGY (GMIT) IV

BACKGROUND

The Mongolian national strategy for implementing the Sustainable Development Goals launched in 2016 includes the objective to develop internationally competitive university education. Since 2012, the Mongolian Government has initiated academic and institutional reforms to design more practical teaching, research, and corporate cooperation to close the gap between employers' needs and graduates' skills sets.

The GMIT responds to these reforms and to the demand for highly qualified engineers in the Mongolian natural resources sector and in downstream industries. It transfers international scientific expertise and modern academic standards to Mongolia.

The project enhances the GMIT's institutional and financial capacities focusing on:

- Increasing the attractiveness of the GMIT
- Strengthening the GMIT's cooperation with industry
- Further developing into a quality oriented and efficient university
- Expanding the GMIT campus

The project supports the development of practice-oriented courses, provides consultation on institutional development, and advises on quality management, qualification in teaching, and methodology. It supports the GMIT in becoming a leading university in the Mongolian higher education landscape and in expanding the range of its services.

OBJECTIVE

The institutional and financial capacities of the GMIT, educating qualified specialists and creating scientific know-how for the Mongolian economy, are strengthened.

| | |
|------------------------------|--|
| Commissioned by | German Federal Ministry for Economic Cooperation and Development (BMZ) |
| Project area | GMIT campus in Nalaikh / Ulaanbaatar |
| Lead executing agency | Mongolian Ministry of Education and Science (MEDS) |
| Duration | 01/2024 - 12/2026 |



GMIT students conducting experiment



ATTRACTIVE GMIT FOR YOUTH

The project supports increasing the attractiveness of GMIT for young people of all gender.

Continuous support and technical advice are offered for the GMIT team to analyse the academic programmes and strengthen the international cooperation and partnerships with German universities.

Technical advice on student recruitment, measures to improve the learning environment for female students, and the (re)accreditation of study programs will be provided.



COOPERATION WITH INDUSTRY

The project also supports the GMIT in fostering the cooperation with industry in the areas of applied research and further education.

The GMIT's Strategic Research Development Fund will be evaluated and the updated edition will be supported.

In line with the business needs and demand, further training for businesses will be analysed and further developed.



QUALITY ORIENTED AND EFFICIENT UNIVERSITY

The institutional blended learning concept with regard to teaching quality and IT infrastructure will be developed and implemented. Furthermore, the project will offer technical advice on areas such as: human resources, partnership management, fundraising, and networking to create a quality oriented and efficient university.

The GMIT also serves as a model for the Mongolian higher education sector by applying the principles of modern university management and institutional autonomy. Knowledge transfer from GMIT to the Mongolian university landscape will be supported as well.



CAMPUS EXPANSION

The expansion of the GMIT campus is supported through the joint efforts of German Financial and Technical Cooperation. The construction of a new multi-functional building is carried out with the support of Financial Cooperation and the equipment will be procured by the GMIT project. It is planned to be operational by fall of 2025. The building features laboratories, which will strengthen the GMIT's ability to conduct industry-driven research.



GMIT students celebrating their graduation ceremony



Appreciation expressed by student

Published by: Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH
Contact: Mr. Sebastian Burghof
"German-Mongolian Institute for Resources and Technology - IV" (GMIT) project
Naiman Zovkhis building, 5th floor, Seoul street
Sukhbaatar District, Ulaanbaatar 14251,
Mongolia

T: +976 11 31 3030
E: sebastian.burghof@giz.de
I: www.giz.de/mongolia

Date: January 2024
Photo credit: Enkhbayar Purevdorj
Layout: GIZ Mongolia

In cooperation with: Mongolian Ministry of Education and Science (MEDS)

On behalf of: German Federal Ministry for Economic Cooperation and Development (BMZ)

GIZ in Mongolia is responsible for the content of this publication.